



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Аялал жуулчлал**

Индекс: **D101501**

Шинжээчийн баг:

Ахлагч: **Д.Гансүх /Ph.D/**  
Гишүүд: **С.Норжинлхам /Ph.D/**  
**Н.Батцэнгэл**

## Агуулга

<b>Товчилсон үгийн тайлбар</b>	4
<b>I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт</b>	5
<b>II. Сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга</b>	6
<b>III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b>	6-37
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	6-10
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10-14
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	14-17
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	17-21
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	21-27
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	27-32
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	32-34
<b>IV. Уулзалтад оролцогчдын нэрс</b>	38
А. Багш нарын нэрс	
Б. Оюутнуудын нэрс	
В. Ажил олгогчдын нэрс.	
Г.Төгсөгчдийн нэрс	
<b>V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал</b>	40
<b>VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b>	40
<b>VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b>	40

## Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХИ	Гадаад Хэлний Институт
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
МНСК	Монголын Номын Сангуудын Консорциум
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ӨҮТ	Өөрийн Үнэлгээний Тайлан
СУИС	Соёл Урлагийн Их Сургууль
СЭЗИС	Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль
ТББ	Төрийн Бус Байгууллага
УЗ	Удирдах Зөвлөл
ХБК	Хөгжим Бүжгийн Коллеж
ХБСТ	Хүмүүнлэг, Боловсрол Судлалын Тэнхим
ХК	Хувьцаат компани
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭШӨ	Эрдэм шинжилгээний өгүүлэл
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	<b>Соёл Урлагийн Их Сургууль</b> Mongolian National University of Arts and Culture <b>Соёлын Сургууль</b> School of Culture	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	<b>Аялал жуулчлал</b> Tourism	
Индекс	<b>D 101501</b>	
Шинжээчид	<p><i>Шинжээчийн багийн ахлагч:</i> <b>Д.Гансүх</b> Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төвийн УЗ-ын дарга, доктор</p> <p><i>Шинжээчийн багийн гишүүд:</i> <b>С.Норжинлхам</b> СЭЗИС-ийн Соёл иргэншил, аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч, доктор <b>Н.Батцэнгэл</b> Монголын Зочид Буудлуудын Холбооны гүйцэтгэх захирал, үндэсний сургагч, үнэлгээ баталгаажуулагч <b>Г.Даваажаргал</b> Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн, доктор, дэд профессор</p>	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн		
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.05.25	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.06.02-03	СУИС-ийн Соёлын Сургууль дээр очиж шинжээчид ажилласан.
	2022.06.10	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга

СУИС-ийн “Аялал жуулчлал” хөтөлбөрийн хувьд Соёлын коллежид 1992 оноос “Музейн арга зүйч, жуулчлал зохион байгуулагч” мэргэжлээр, 2000 оноос “Аялал жуулчлал зохион байгуулалт” мэргэжлээр бэлтгэж байв. Улмаар 2004, 2006 онуудад Гадаад хэл- Аялал жуулчлал мэргэжлээр элсэлт авч 2008, 2010 онд төгсгөсөн бол 2005 онд Аялал зохион байгуулагч-Хөтөч мэргэжлээр элсэлт аван 2009 онд төгсгөсөн. Соёл Урлагийн Их Сургуульд 2009-2014 оны хооронд Соёлын аялал жуулчлал мэргэжлээр 47, 2015-2021 оны хооронд “Аялал жуулчлал” хөтөлбөрөөр 68 төгсөгч төгссөн буюу нийт 27 удаагийн төгсөлт хийжээ.

### Хөтөлбөрийн товч мэдээлэл

Хөтөлбөрийн нэр, индекс	Мэргэшиж буй салбар	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Аялал жуулчлал D 101501	Аялал жуулчлал, соёл	Доктор /Ph.D/ Б.Мөнхбадрал	Өдөр	4 жил	127

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны 2019 оны 3-р сарын 21-ны өдрийн 960028 тоот тусгай зөвшөөрлөөр D101501 индексээр “Аялал жуулчлал” хөтөлбөрийн сургалт эрхлэх эрхийг авсан.
- Тус хөтөлбөр нь 2020 оны 6-р сарын 10-нд Хөтөлбөрийн ерөнхий хороогоор, 2020 оны 6 сарын 18-нд Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжиж, СУИС-ийн захирлын 2020 оны 8-р сарын 25-ны өдрийн А/176 тоот тушаалаар батлагдсан.
- СУИС-ийн Соёлын сургуулийн захирлын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 21 тоот тушаалаар “Аялал жуулчлал” хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийг баталсны дагуу 2021 оны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, улмаар сургалтын хөтөлбөрийг 1) соёлын аялал жуулчлал, 2) аялал жуулчлал-гадаад хэл, 3) зочлох үйлчилгээний соёл гэсэн гурван чиглэлд мэргэшихээр тогтоосон байна.

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

#### *Онцлог зүйл / Туршлага:*

- Монголын аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагыг судалж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байна.
- Мөн “Алсын хараа-2050” зэрэг Монгол улсын эдийн засаг-нийгмийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон СУИС-ийн 2018-2024 оны мастер төлөвлөгөөг үндэслэсэн.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн STEEP шинжилгээ (ӨҮТ, 17-р тал).
- Аялал жуулчлалын хөтөлбөрөөр сургалт явуулдаг 4 их, дээд сургуулиудын болон соёлын аялал жуулчлалын гадаадын ижил төсөөтэй 5 их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдийн харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.
- Сүүлийн 6 жилд төгссөн нийт 57 төгсөгчдөөс мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, мэдлэг, ур чадварын төлөвшлийн үнэлгээг авч, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд тусгасан.

#### *Анхаарах асуудал:*

- Хөтөлбөрийн зорилгод зааснаар төгсөгч нь судлаач-мэргэжилтэн байхаар томъёолсон нь ерөнхий бөгөөд, хөтөлбөрийн онцлог эрэлт хэрэгцээнд нийцээгүй.
- Хөтөлбөрийн сонирхогч талуудыг дутуу тодорхойлсон буюу ажил олгогч тал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ хангалтгүй зөвхөн сургуулийн дотоод дүрэм журам, төгсөгчдийн судалгаагаар хязгаарлагдсан байна.
- Төгсөгчийн загвар ерөнхий бөгөөд албан ёсоор батлагдаагүй.

#### *Зөвлөмж:*

- Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны 5-р сарын 09-ны өдрийн А/160 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс”-тэй уялдуулах.
- Соёлын болон аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шинэ нөхцөл байдлыг тусгах.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### *Илрэл нотолгоо:*

- Соёлын сургуулийн захирлын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 21 тоот тушаалаар “Аялал жуулчлал” хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, шинэчлэх ажлын хүрээнд уг хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнг үр дүнд суурилсан боловсролын арга зүй (CDIO)-ээр боловсруулсан байна.
- *СУИС-ийн алсын хараа:* “Бүс нутгийн шилдэг сургуулиудын эгнээнд багтсан соёл, урлагийн төрөлжсөн их сургууль болно”.
- *СУИС-ийн эрхэм зорилго:* “Соёл урлагийн мэргэжлээр авьяаслаг бүтээлч, шилдэг уран бүтээлч, мэргэжилтнийг бэлтгэж, төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлогод

дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажлыг явуулдаг монгол үндэсний соёл урлагийн гол уурхай болно”.

- **Хөтөлбөрийн эрхэм зорилго:** Соёл судлал, үндэсний соёл, угсаатны зүй, соёлын өвийн онолын мэдлэгийг ерөнхий аялал жуулчлал, соёлын аялал жуулчлалын онол, практиктай хослуулсан төрийн соёлын болон аялал жуулчлалын бодлогыг судлах, шинжлэх, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйц, судлан шинжлэх хийгээд бизнесийн авьяастай, зохион байгуулах, удирдан манлайлах цогц чадвар бүхий үндэсний ажил мэргэшлийн хүрээний шаардлагад нийсэн чадвар, дадлыг эзэмшсэн бүс нутгийн болон дэлхийн хэмжээний чадварлаг “аялал жуулчлалын мэргэжилтэн”-ийг бэлтгэнэ хэмээн СУИС-ийн эрхэм зорилготой уялдаа холбоотой боловсруулсан байна. /ӨҮТ, 18-19-р тал/
- **Хөтөлбөрийн зорилтууд:** 1) Аялал жуулчлалын мөн чанар, үзэл баримтлал, эрх зүйн орчны бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд бүтээлчээр хандах, дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага, орчны хүчин зүйлсийн нөлөөллийг уялдуулан тодорхойлох, дүн шинжилгээ хийх; 2) Нүүдэлчдийн уламжлалт соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлийг тодорхойлсон, нийгмийн хөгжилд бодитой үр нөлөө үзүүлэх мэдлэг, ур чадвар, хандлагатай байх; 3) Соёл хоорондын, салбар хоорондын харилцааны ур чадвартай, гадаад хэлний, мэдээллийн технологийн мэдлэгээ тасралтгүй хөгжүүлж хэрэглэдэг байх; 4) Нийгмийн эрэлт хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагад нийцсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл / Туршлага:*

- Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгсөгчийн (мэргэжилтний) загварыг СУИС-ийн төгсөгчийн загварт үндэслэн тодорхойлсон (ӨҮТ, 19-р тал) нь хөтөлбөрийн зорилгод нийцэж байна.

*Анхаарах асуудал:*

- Үр дүнд суурилсан боловсролын арга зүй (CDIO)-г “Аялал жуулчлал” хөтөлбөрийн хүрээнд бүрэн хэрэгжүүлэх ажил эхлэлийн шатанд байна.

*Зөвлөмж:*

- Ажил олгогчид, мэргэжлийн Холбоодын төлөөллүүдийг оролцуулан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг хамтран гүйцэтгэх.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, 2018-2024.

- СУИС-ийн захирлын 2018 оны 11-р сарын 16-ны өдрийн А/393 тоот “Соёл Уралгийн Их Сургуульд үр дүнд суурилсан боловсролын арга зүйг нэвтрүүлэх тухай” тушаал.
- 2020 оны 6-р сарын 18-ний өдөр СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар батлагдсан “Аялал жуулчлал” хөтөлбөрийн ном.
- D101501 индекстэй “Аялал жуулчлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийн баримт бичигт сургалтыг 4 жилийн хугацаанд 127 багц цагаар хэрэгжихээр төлөвлөсөн. Үүнээс: Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2014 оны 4-р сарын 28-ний өдрийн А/174 тоот тушаалын шаардлагын дагуу дүгнэж үзэхэд: “Аялал жуулчлал” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд ерөнхий суурь хичээл 27,6%, мэргэжлийн суурь хичээл 30%, мэргэшүүлэх хичээлүүд 42,4%-ийг тус тус эзэлж байна.

*Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*Онцлог зүйл/Туршлага:*

- Аялал жуулчлал хөтөлбөрөөр Монгол Улсын хэмжээнд 20 гаруй их, дээд сургуульд мэргэжилтэн бэлтгэж буй хэдий ч соёл судлал, үндэсний соёл, угсаатны зүй, соёлын өвийг аялал жуулчлал, соёлын аялал жуулчлалын онол, практиктай хослуулсан сургалтыг зөвхөн СУИС-ийн Соёлын Сургуульд явуулж байна.
- Европын Холбооны ERASMUS хөтөлбөрийн “Ажил дээрх дадлагад суурилсан сургалтыг нэвтрүүлэх замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” MONGWBL /2021-2023/ төсөлд хамрагдсан.
- Хөтөлбөрийн номыг 2022 оны 05-р сард шинээр хэвлэн сургалтад ашиглаж эхэлсэн.

*Анхаарах асуудал:*

- Сургалт болон ажил олгогчдын хоорондын харилцаа бараг байхгүй, сул.
- Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээ байнга хувьсан өөрчлөгдөж байгааг хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгад тусгах талаар тодорхойгүй.

*Зөвлөмж:*

- Хөтөлбөрийг Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны 5-р сарын 09-ний өдрийн А/160 тоот тушаалаар батлагдсан мэргэжлийн индексийн хүрээнд Европын Холбооны ERASMUS хөтөлбөрийн “Ажлын байранд суурилсан сургалтыг бэхжүүлэх” MONGWBL төслийн үр дүнд үндэслэн сайжруулах шаардлагатай.

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**



## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

*Илрэл нотолгоо:*

- “Аялал жуулчлал” хөтөлбөрийн хувьд 2014 онд батлагдсан хөтөлбөрөөр III, IV курсийн оюутнууд, 2020- 2021 онд шинэчлэн батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр I, II курсийн оюутнууд хичээллэж байна.
- Соёлын сургуулийн захирлын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 21 тоот тушаалаар “Аялал жуулчлал” хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийг баталсан байна. Энэ ажлын хүрээнд “Аялал жуулчлал” хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнг үр дүнд суурилсан боловсролын арга зүй (CDIO)-ээр шинэчлэн боловсруулсан байна. /ӨҮТ, 17-р тал/
- Сургалтын төлөвлөгөөнд “Аялал жуулчлал” хөтөлбөрийг Соёлын аялал жуулчлал, Гадаад хэл-Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний соёл гэсэн үндсэн 3 чиглэлд мэргэших хөтөлбөрийн өөрчлөлт хийжээ.
- СУИС нь 2011 оноос удирдлагын мэдээллийн UNICULTURE системийг, 2020 оноос цахим сургалтын программ нэвтрүүлэн ажилласан байна. Энэхүү систем нь 2019 оноос идэвхтэй ажиллаж эхэлсэн нь багш нарын хичээлийн хөгжил, цаг хэмнэхэд ач холбогдолтой, хэрэглээ болсон байна.
- 2021 оны 11-р сард 2 удаа хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг шинэчлэн боловсруулж, Соёлын сургуулийн багш нар, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн тус хөтөлбөрт хичээл зааж буй бүх багш нарт зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээл хоорондын холбоос бүхий мэдээллийг илгээж, хичээлийн хөтөлбөр тус бүрийг шинэчлэн боловсруулсан байна.
- Дадлага хийх нийт цаг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн семинарын цаг, танилцах (1кр), үйлдвэрлэлийн дадлага (2кр), дипломын өмнөх дадлага (2кр)-уудаас бүрддэг байна.
- Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган ажил мэргэжлийн дээд сургуулийн 2019 оны 04 сарын 24-ий өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т сургалт зохион байгуулах, дадлагажуулах чиглэлээр гэрээ байгуулсан байна.

*Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага*

- 2020 онд сургалтын төлөвлөгөөний шинэчлэлд үндэслэн, 2021 онд “Аялал жуулчлал” хөтөлбөрийн хичээлийн хөтөлбөрт шинэчлэл хийсэн байна.

- Жил бүр мэргэжлийн тэнхим хээрээр явах маршрутыг тогтоон удирдамж гарган, аялдаг.

**Анхаарах асуудал:**

- СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2020 оны 06 сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцэж сайшаасан сургалтын төлөвлөгөөний дагуух өөрчлөлт хичээлүүдийн агуулгад туссан хэдий ч хэрэгжүүлж эхлээгүй байгааг анхаарах.
- Дадлагажуулах хугацаа бусад ижил мэргэжлийн сургуулиудтай ойролцоо байгаа ч ялангуяа энэ салбарын мэргэжилтнийг бэлтгэх тусгай хэрэгцээ байгааг судалж, дүгнэлт гарган, байгууллагуудын гэрээ, хэлэлцээрийг баримт нотолгоотой харуулах, ажил олгогчидтой хамтран ажиллах, онол гэхээс илүүтэйгээр ажлын байранд дадлагажих хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээтэй байгаа нь оюутнуудтай ярилцахад мөн дурдагдсан болно.
- Төгсөгчид болон ажил олгогчидтойгоо эргэх холбоотой ажиллахад анхаарах, өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг сайжруулах.
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар, Нийслэлийн Соёл, Урлагийн Газар, Dream land, Соёл, Урлаг Судлалын Хүрээлэн зэрэг байгууллагатай бичгээр гэрээ үйлдээгүй боловч албан бичгээр харилцаж, оюутнаа дадлагажуулдаг байна. Үүнийг албажуулах шаардлагатай.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн PLO, CLO-ийн уялдаа холбоо болон суралцахуйн үр дүнг бодитой тооцох, үнэлэх асуудалд багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Үндэсний болон олон улсын ижил төстэй сургалтын хөтөлбөрүүдийг харьцуулан судлахдаа хөтөлбөрийн зорилго, зорилт, багц цагийн харьцаа, хичээлийн тоог харьцуулахаас гадна тухайн хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, онол-практикийн зохистой харьцааг хэрхэн хангаж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийх;
- Суралцагчдад хөтөлбөрийн тухай мэдээлэл болон мэргэжлийн, хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд ямар ямар өөрчлөлтийг хийж байгаа талаар тодорхой мэдээллийг хүргэж, тэдний санаа бодлыг сонсох тал дээр анхаарч ажиллах;
- Төгсөгчдийн судалгаагаар гадаад хэл хэрэгцээтэй гэсэн хамгийн өндөр үзүүлэлт гарсан хэдий ч дижитал шийдэл, IT мэдлэг чадварыг түлхүү олгох хэрэгцээ шаардлага, улмаар зах зээлд хөрвөх чадвар шаардлагатайг анхаарах;

**Шаардлага:**

- Хөтөлбөрийн дэд хороонд сонирхогч талууд, түүний дотор аялал жуулчлалын салбарын төлөөллийг оруулж хөтөлбөрийн сургалтыг агуулгыг сайжруулахад хамтран ажиллах;
- Оюутан солилцооны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх /дотоод ба гадаад/;

## 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### *Илрэл нотолгоо:*

- “Соёл Урлагийн Их Сургуулийн бакалаврын сургалтын журам”-ын 4.1.8 заалтад 2019.05.30-ны өдрийн А/213 тоот тушаал, түүний хавсралт орсон байна. Тиймээс багш нар зааж буй хичээлийн онцлогийг харгалзан үзэж, олон төрлийн арга зүйг ашиглан хичээл сургалтаа хөтлөн явуулж байгаа талаар дурдсан байна.
- СУИС –ийн захирлын 2015.06.05-ны өдрийн А/149 тоот тушаал, түүний хавсралт болох “Соёл Урлагийн Их Сургуулийн бакалаврын сургалтын журам”-ын 4.1.8 –д заасны дагуу бакалаврын хөтөлбөрт судлах хичээлүүдийн агуулгыг харьяалах тэнхим боловсруулах ба багш бүр хичээл заахдаа мэдлэг, туршлагадаа тулгуурлан, судалж буй оюутнуудын мэргэжлийн онцлог, эрэлтэд нийцүүлэн, баяжуулан зааж болдог бөгөөд одоо мөрдөж буй мөн захирлын 2019.05.30-ны өдрийн А/213 тоот тушаал, түүний хавсралт болох “Соёл урлагийн их сургуулийн бакалаврын сургалтын журам”-ын 4.1.8-д энэ заалт орсон.
- Соёлын сургуулийн бүтцэд үйл ажиллагаагаа явуулж буй ХБСТ болон ГХИ-ийн багш нар голчлон сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хичээлүүдийг ордог бол Соёл судлалын тэнхимийн багш нар мэргэжлийн суурь, мэргэжлийн бүлгийн хичээлүүдийг заадаг байна.
- Сургалтын үйл явцыг их дээд сургуулиудын нийтлэг арга зүйгээр зохион байгуулан явуулж байна. (ӨYT 43-р тал, *Хүснэгт 2.8. Сургалтын үйл явцын зохион байгуулалт, ашиглаж буй аргууд*)

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

### *Онцлог зүйл/Туршлага:*

- Сургалтын арга зүйд гарч буй өөрчлөлт ялангуяа цар тахлын үеэр онлайнаар зохион байгуулсан сургалтын зарим нэг сайн тал нь оюутан бүрд багшийн бэлдсэн хичээлийн материалууд (лекц бүрэн эхээрээ, танилцуулга үзүүлэн, видео бичлэг гэх мэт) очдог болсонд оршиж байна гэж суралцагч оюутнууд үзсэн байна.
- ДИНАМИК суралцагчдад зориулсан талбар, UNICULTURE удирдлага мэдээллийн систем нь цахим сургалтын гол хэрэгсэл болон ашиглагдсан байна.
- Бүтээлч аргууд ашигладаг талаар, мөн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлээр зааглан арга зүйгээ сонгодог талаар дурдсан байна.

### *Анхаарах асуудал:*

- Орчин үеийн техник технологи болон сонирхолтой арга ашиглах, залхаахгүй байх (хэт их ярих, залхтал лекц бичүүлэх) зэрэгт анхаарах талаар уулзалтад оролцогч оюутнуудын саналд дурдагдаж байв.

- Багш нарын арга зүйд шинжилгээ хийх, хөтөлбөрийн зүгээс туслан дэмжиж, хөгжүүлэх хэрэгцээ байна.

*Зөвлөмж:*

- СУИС-ийн зүгээс арга зүйн хөгжлийг хангах;
- Багш нар хоорондоо туршлага солилцох, арга зүйн хөгжлийг бусдад түгээх, урамшуулах;
- Орчин үеийн дэвшилтэт арга технологийг багаараа ашиглаж, хэвших;
- Боловсрол судлалын асуудлаар сургалт зохион байгуулж хэвших, оюутны цогц чадамжид чиглэсэн хөтөлбөрийн боловсруулалт хийх;

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2014 оны 07 сарын 02-ны өдрийн 03 тоот тогтоол, СУИС “Дүрэм журмын эмхэтгэл” 6.1.1. Х.165 - 169.
- “Багш нар бие даалтын болон бусад нэмэлт даалгавар, мэдээллийг оюутанд онлайн хэлбэрээр өгч, явцын зөвлөгөө өгч үнэлдэг. Энэ нь цаг хугацаа хэмнэж оюутны бие даан суралцах чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн багш нар и-мэйлээр оюутны бие даалтын ажил авч дүгнэхээс гадна сургалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг өргөн ашиглаж байгаа” талаар тайланд тэмдэглэсэн байна.
- СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2014 оны 07 сарын 02-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан СУИС-ийн дүрэм журамд зааснаар: Тухайн хичээлээр оюутан эзэмшвэл зохих мэдлэг олж авахын тулд улиралын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө, тухайн хичээлийг заасан багшаар 70 хүртэл оноогоор, оюутны эзэмшсэн мэдлэгийн түвшнийг улиралын шалгалтын 30 хүртэл оноогоор тус тус заавал үнэлүүлнэ. Багшийн үнэлгээний 70 оноо нь дөрвөн улирлын хугацаанд хүчинтэй байна. Эдгээрийн нийлбэрийн 100 хүртэл оноог лавлах хүснэгтийг ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.
- Сургах үйл явц нь зөвхөн мэдээлэл авах, дамжуулах төдийгөөр хэрэгждэггүй бөгөөд оюутан өөрийн үзэл бодлоо илэрхийлж бусадтай санал бодлоо хуваалцаж, харилцан ярилцах замаар мэдлэгийг олж авахаас гадна хичээл заагч багшийн сургалтын арга зүй үнэлгээний хэлбэр нь хэрхэн оновчтой байхаас оюутны ахиц дэвшил ихээхэн хамаарна.
- СУИС-ийн оюутныг үнэлэх нийтлэг арга зүйг ӨҮТ-ын 45-р талд байгаа хүснэгт 2.11-ын “Оюутныг үнэлэх арга зүй”-д дэлгэрэнгүй үзүүлсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*Онцлог зүйл/Туршлага:*

- Суралцагчдын үнэлгээ, шалгалтын оноог UNICULTURE удирдлага мэдээллийн системд оруулснаар баталгаажиж цаашид хичээлийг үргэлжлүүлэн судлах, курс ахин суралцах боломжтой. Дүн баталгаажсаны дараа дүгнэгдсэн байдалдаа сэтгэл ханамжгүй бол тухайн оюутан өөрийн хүсэлтээр тухайн улиралд R (СУИС-ийн дүрэм журмын

эмхэтгэлийн 6.2-т заасан) үнэлгээ тавиулж, дараа улиралд дүнгээ ахиулах боломжтой. Энэхүү оюутны үнэлгээний зарчим нь бүх оюутанд ижил тэгш үйлчлэх нөхцөлийг хангасан байна.

**Анхаарах асуудал:**

- Суралцагчдын сурлагын ахиц, хичээлд унасан оюутны тоо, дүгнэлт, статистик тоон мэдээллийн боловсруулалтад хийсэн дүн шинжилгээ хийх шаардлагатай.
- Үнэлгээний батлагдсан журамтай хэдий ч чадвар, хандлагыг хэрхэн үнэлэх үнэлгээний аргууд нь тодорхой бус, шалгалтын материалын санг хичээл бүрээр бүрэн бүрдүүлээгүй байна.
- Хичээл тус бүрээр оюутныг үнэлэх аргачлал тодорхой бус тул хичээлийн хөгжлийг баримтжуулах боломжгүй.

**Зөвлөмж:**

- Системд автоматаар гарч байгаа дүнгийн үзүүлэлтэд хичээл бүрээр анализ хийх, сургалтын үр дүнгээ хэмжих, тайлагнаж хэвших, улмаар сургалтын үйл ажиллагаандаа тасралтгүй шинэчлэл хийх;
- Үнэлгээний бодитой байдалд дүн шинжилгээ хийх, оюутнаас санал асуулга авч, нэгтгэх, дүгнэх;
- Сургалтын хөтөлбөрт багтсан хичээл тус бүрийн үнэлгээний аргачлалуудыг тодорхой болгох;
- Шалгалтын материалын санг хичээл бүрээр боловсруулан бүрдүүлэх;
- Үнэлгээний арга болон тестийн санд үнэлгээ дүгнэлт хийж, сайжруулах;
- Үнэлгээний нэгдсэн системийг бүрдүүлэх;

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

**3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн 13 танхим, 3 лаборатортой. Зайн 1 сургалтын лабораторитой, хичээлийн 2-р байранд сүүлийн үеийн ухаалаг LCD дэлгэц, проектор, шилэн самбар, тав тухтай ширээ сандлаар тохижуулсан.
- 30 оюутны багтаамжтай 4 танхимд гадаад хэл, мэдээллийн технологийн 2 лаборатори, 160 оюутны багтаамжтай лекцийн 2 танхим, 60–80 оюутны багтаамжтай 3 семинарын

танхимтай, аялал жуулчлалын лаборатори 1, музейн сургалтын лаборатори 1, өв соёлын өргөө 1, нийт 517м<sup>2</sup> талбайтай, 255 суудал бүхий 9 уншлагын танхим, хөгжим сонсголын танхимтай.

- Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлагын биелэлтийн харьцуулалтыг 21 үзүүлэлтээр хийсэн. Уг хүснэгтээс үзэхэд нэг оюутанд ногдох талбайн хэмжээ харьцангуй бага болох нь харагдаж байна. (ӨҮТ 50-р тал).

#### *Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

##### *Онцлог зүйл / Туршлага:*

- Суралцахуйн орчин шаардлагад нийцсэн, сургалт нь онол, дадлагын хичээл явуулах нөхцөл бүрдсэн хэдий ч зарим тохиолдолд анги танхимын хүрэлцээ хангалтгүй байна.
- Мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийн чухал хэсэг болох лаборатори, түүнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг төслөөр шинэчлэн байгуулж ашиглаж байна.

##### *Анхаарах асуудал:*

- Суралцагчдын тоо нэмэгдэхэд анги танхимын хүрэлцээ бага, нэг оюутанд ноогдох талбай хангалтгүй.
- Сургалтын орчныг тасралтгүй сайжруулахад цаашид анхаарч ажиллах.

##### *Зөвлөмж:*

- Оюутнууд сургалтын орчинг 3,5-3,6 гэж дундаж үнэлгээ өгсөн тул орчны сайжруулалт хийх;
- Суралцахуйн ур чадвар дадал эзэмших орчныг (анги, танхим, лаборатори) төрөлжүүлэн шинээр бий болгох;
- 2018 онд хот төлөвлөлтийн газартай хамтарсан барилгын өргөлтгөлийн барилгын зургийг батлуулсан нь сайшаалтай ч хэрэгжүүлэлтийг ханган ажиллахад анхаарах;

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

##### *Илрэл нотолгоо:*

- Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлагын биелэлтийг нийт 21 үзүүлэлтээр харьцуулан, дүгнэлт гаргаж ажилласан байна.
- Сургуулийн зүгээс жил бүр сургалт явуулах орчныг хөгжүүлэх, стандартад нийцүүлэх тал дээр анхаарч, урсгал болон их засвар, хичээлийн байрны өргөтгөл, тоног төхөөрөмж, эд хогшил, худалдан авах зардлыг харьцуулсан судалгаа гаргасан ба 2019-2020 онд өмнөх оны мөн үеэс 49.64%-аар буурсан бол 2020-2021 онд 96.4%-аар өссөн байна. (ӨҮТ хуудас 51)

- Зайн сургалтын кабинетын тоног төхөөрөмж, Аялал жуулчлалын лаборатори байгуулахад дээрх төсөв зарцуулагдсан ба сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн шинэчлэл хийсэн.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Европын Холбооны ERASMUS хөтлбөрийн “Ажил дээрх дадлагад суурилсан сургалтыг нэвтрүүлэх замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” MONGWBL /2021-2023/ төсөлд хамрагдаж буй нь цаашид сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх олон улсын жишигт хүргэхэд ач холбогдолтой

*Анхаарах асуудал:*

- Оюутан нэг бүрд хүргэх сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх

*Зөвлөмж:*

- Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхэд зориулсан анги танхим сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх;

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

*Илрэл нотолгоо:*

- Соёлын сургууль нь удирдлагын мэдээллийн UNICULTURE систем, КОХА номын сангийн системтэй.
- Зайн сургалтын хичээл сургалтыг Moodle программ хангамж дээр тулгуурлан зохион байгуулж байсан бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд “Open СУИС” цахим сургалтын системийг нэвтрүүлж сургалтын үйл ажиллагааг явуулж байна. СУИС-ийн болон бүтцийн сургуулиудын цахим хуудсыг 2016, 2019 онд тус тус шинэчилсэн.
- Юнивишний (Univision) 40 Mb хэмжээний хурдтай интернет ашиглаж байна.
- СУИС-ийн номын сан нь Төв номын сан, Соёлын сургуулийн номын сан, Радио, телевиз, медиа урлагийн сургуулийн номын сан, Завханы ХБК-ийн номын сан гэсэн 4 үндсэн номын сан, 5 уншлагын танхим, 4-н ганцаарчилсан танхим, 50,000 номын фондтой.
- Мэргэжлийн багш нар 2 сурах бичиг, 5 гарын авлага, хамтарсан бүтээл 4-ийг хийсэн.
- Ерөнхий суурь хичээлийн 802, мэргэжлийн суурь 133, мэргэжлийн хичээл 235 ш ном сурах бичгийн фондтой.
- СУИС-ийн захирлын 2020 оны “Ном, сурах бичиг, гарын авлагыг зурган хэлбэрт оруулах тухай” А/307 тоот тушаал, мөн 2021 оны “Ном, сурах бичиг, гарын авлагыг дотоод сүлжээнд байршуулах тухай” А/09 тоот тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу сургалтад ашиглагдах 188 нэрийн ном, сурах бичиг, гарын авлагыг Open SUIС сургалтын системд байршуулсан.
- Мөн МНСК-иас DOAJ - THE DIRECTORY OF OPEN ACCESS JOURNALS, DOAB DRETORY OF OPEN ACCESS BOOKS гэсэн 2 мэдээллийн санг ашиглах боломжийг нээж өгсөн.

## Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Open.mnuac.edu.mn, Багшийн вэб, оюутны вэбийг багтаасан UNICULTURE систем [teacher.mnuac.edu.mn/](http://teacher.mnuac.edu.mn/), [student.mnuac.edu.mn/](http://student.mnuac.edu.mn/) ашиглалт сайн. СУИС-аас байнгын дүгнэлт мэдээлэл боловсруулалт хийж ажилладаг нь тогтмолжсон байна.

### Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийн мэргэжлийн сурах бичиг, гадаад хэлээр ашиглах ном сурах бичгийн хангамж хүрэлцээгүй байна.
- Гадаад сурах бичиг, судалгааны ажлуудаар баяжуулах шаардлагатай

### Шаардлага:

- Сургалтын цахим материалуудыг илүү боловсронгуй болгон E-контентын түвшинд хөгжүүлж сайжруулах;
- Олон улсын түвшинд нэвтэрч буй судалгааны болон эрдэм шинжилгээний бүтээлүүдээр баяжуулах;
- Аялал жуулчлалын хөтөлбөрийн мэргэжлийн сурах бичиг, гадаад хэлээр ашиглах ном сурах бичгийн хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх

## 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

### Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- СУИС-д хэрэгжиж буй хөтөлбөр бүрийн талаарх элсэгчдэд зориулсан танилцуулга цахим контент (CD), радио, телевизийн нэвтрүүлгийг бэлтгэж, нийтийн сүлжээнд байршуулсан.
- Аялал жуулчлалын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн дараа, хариуцсан нэгж Соёлын сургууль нь маркетингийн албатай хамтран ажиллах төлөвлөгөө танилцуулсан.
- СУИС нь элсэгчдэд зориулсан open.mnuac.edu.mn цахим хуудсыг ажиллуулж элсэгчдэд нээлттэй мэдээллийг хүргэдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөлд SWOT шинжилгээ хийсэн байна.
- Аялал жуулчлалын бакалаврын сургалтын хөтөлбөр болон магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд хөтөлбөрийн хэрэгжилтийн зорилгыг тодорхойлон бичсэн.



- СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 12-р сарын 21-ний өдрийн 13-р тогтоолоор “Соёл урлагийн их сургуулийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2018-2024)” батлан хэрэгжүүлж байна.
- СУИС-ийн захирлын 2019 оны 04-р сарын 15-ны өдрийн “Сургалтын хөтөлбөрүүдэд шинжилгээ хийж, сайжруулах тухай” А/154 тоот тушаалын дагуу “Соёл судлал” хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, сайжруулах баг байгуулагдаж, хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан.
- “Соёлын сургуулийн сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах” тухай Соёлын сургуулийн захирлын 2020 оны 01-р сарын 23-ны өдрийн 02 тоот тушаал, “Аялал жуулчлал” сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийг шинэчлэн ном болгон гаргах ажлын хэсэг батлах тухай Соёлын сургуулийн захирлын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 21 тоот тушаал тус тус батлагдсан.
- СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2014 оны 07-р сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцэн сайшааж батлагдсан “Аялал жуулчлал” хөтөлбөр хэрэгжиж байгаа ба энэ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөн дэх Соёл чөлөөт цагийн үйлчилгээ чиглэлийг 2018 оны 06-р сарын 25-ны өдөр “Аялал жуулчлал, чөлөөт цагийн менежмент” болгон салгаж, сургалтын төлөвлөгөөг батлуулж, соёлын үйлдвэрлэлийн тэнхимийн сургалтад шилжүүлсэн. Энэ өөрчлөлтийн дагуу СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2020 оны 06-р сарын 18-ны өдрийн хурлаар “Аялал жуулчлал” сургалтын төлөвлөгөөг хэлэлцэн сайшааж, СУИС-ийн захирлын тушаалаар баталсан.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Хөтөлбөрийн хэрэгжилт, удирдлагын хүрээнд эрх зүйн орчныг сайн бүрдүүлсэн.

*Анхаарах асуудал:*

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт хяналтын тогтолцооны давхцалыг арилгах.
- Хөтөлбөрийн нэгжийн удирдлага, багш нарын хариуцах ажлын чиг үүргүүдийг илүү нарийн тодорхой болгох.

*Зөвлөмж:*

- Удирдлагын нэгдсэн системд хандах үйл ажиллагаанд Соёлын сургуулийн зүгээс тавих хяналтыг сайжруулах;
- Хөтөлбөрийн үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн лицензтэй программ ашиглах;

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

*Илрэл нотолгоо:*

- 2019-2020 оны хичээлийн жилийг “Хамтын ажиллагааны жил” хэмээн зарлан ажилласан.
- 2016-2017 “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлдөг хүчин зүйлс” Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй төсөл.
- 2017-07-01 ЮНЕСКО “Зүүн бүсийн соёлын биет бус өвийн судалгаа” төсөл.
- 2017-10-01-2017-12-01 Халимагийн улсын их сургуультай хамтарсан “Монгол хэлт ард түмнүүдийн орчин үеийн соёл дахь уламжлалт зан заншлуудын үүрэг, ач холбогдол” төсөл.
- 2017-2020 “Франц Монгол соёл хоорондын харилцаа тайлбар толь бичиг” төсөл.
- 2019. 05. 24. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган аймгийн Ажил Мэргэжлийн Дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй.
- 2019.05.26. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймгийн Ажил Мэргэжлийн Дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
- 2018.11-р сар Япон улсад цалинтай дадлага хийх тухай Япон улсын Глов ХК болон IWING ХК-уудтай санамж бичиг.
- 2019-2020 Япон улсын “Нисэко бриж” ХК болон “Tourism” ХК-уудтай оюутан дадлагажуулах хамтын ажиллагааны гэрээ.
- 2017.07.20 СУИС, Флоренцын их сургуультай гэрээ.
- “Соёлын мод”- Олон улсын форум. Зохион байгуулагч БНСУ-ын Daum нийгэмлэг (Daum Society for Cultural Energy), хамтран зохион байгуулагчид Соёл урлагийн их сургууль болон Дорнод Сибирийн улсын соёлын дээд сургуультай гадаад хамтын ажиллагаатай явж ирсэн.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг туршлага хуримтлуулсан.
- Соёл, урлаг болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаатай
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд сургалт, судалгааны бааз, багш судлаачдын хүчээр оролцох зэргээр үндэсний хэмжээнд олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхээр төлөвлөж байгаа.

*Анхаарах асуудал:*

- Одоо хэрэгжиж буй гэрээт ажлуудын хугацаа дуусаж байгаа тул цаашид сунгах үргэлжлүүлэх талаар санаачилга гаргаж ажиллах.

*Зөвлөмж:*

- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Соёлын аялал жуулчлалын хөтөлбөрийг гадаад, дотоодод өргөнөөр сурталчлах;
- Хөтөлбөртэй холбоотой бизнесийн байгууллагуудтай хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх;

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС төсвийн санхүүжилтээс гадна өөрсдийн нөөц бололцоог (аялал жуучлалын чиглэлийн эрдэм шинжилгээ, төсөл хэрэгжүүлэх, гэрээт ажил үйлчилгээ) ашиглан нэмэлт орлого бий болгох эх үүсвэртэй байна.
- Төсвийн зарцуулалтад хяналт тавих үүднээс жил бүр санхүүгийн тайланд хөндлөнгийн байгууллагаар аудитын хяналт хийлгэдэг.
- Хөтөлбөрийн орлого (аялал жуулчлал) 2018-2019 онд 42,2, 2019-2020 онд 38,6, 2020-2021 онд 31,3 сая төгрөг байна.
- Элсэн суралцагчидтай холбоотой орлого, зардлын урьдчилсан тооцоог урьдчилсан байдлаар төсөвлөсөн.
- Нийт ноогдох зардлын хөтөлбөрт ногдох дундаж зардал /Аялал жуулчлал/ 2018-2019 онд 120,193.8, 2019-2020 онд 128,053.3, 2020-2021 онд 119,107.6 мянган төгрөг тус тус ноогддог байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Санхүүгийн удирдлага сайн ажиллаж байна.

*Анхаарах асуудал:*

- Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх, санхүүгийн хувьд тогтвортой байхын тулд даатгал, эрсдэлийн сан бий болгож ажиллах тал дээр анхаарах,

*Зөвлөмж:*

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэх замаар оюутны тоог нэмэгдүүлэх+
- Гадаад, дотоод төслийн болон аж ахуйн гэрээт ажлуудад идэвхтэй оролцож, санхүүжилтийн төрөл хэлбэрийг олшруулах;

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

*Илрэл нотолгоо:*

- Мэдээллийн технологийн хүрээнд цахим орчинд 3 сувгаар 3 контент, 4 лайв, төгсөгчдийн группүүдэд мэдээлэл байршуулан түгээж ажилласан.
- Хөдөлмөрийн зах зээлийн болон салбарын эрэлтийн судалгааг гаргаж ажилласан.

*Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн зах зээлийн тандалт хийж эрэлтийг судлан ажилладаг.

*Анхаарах асуудал:*

- Хөтөлбөрийн сурталчилгаа хангалтгүй, хэт хязгаарлагдмал хүрээнд түгээж байна.

*Шаардлага:*

- Хөтөлбөрийг гадаад зах зээлд сурталчлан ажиллаж элсэгчид судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба нь мэдээллийг ил тод байлгах тал дээр сайн ажиллаж байна. Радио, телевиз, вебсайт болон нийгмийн сүлжээгээр дамжуулан сонирхогч талуудад шаардлагатай мэдээллүүдийг цаг алдалгүй, шуурхай, ил тод мэдээлж байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Олон талт сурталчилгааг таниулга хийгддэг.
- Мэргэжлийн багш нар хөтөлбөр сурталчлах санаачилга сайн сурталчилгааны шторк, контент бэлтгэж ажилласан ба энэ нь жил бүр уламжлал болж хөгжиж байна.
- Үйл ажиллагааны талаарх мэдээллүүд ил тод, шуурхай байгаа нь одоогийн нөхцөл байдалд хурдан өөрчлөгдөж, нийцэж байна. Багш, суралцагч болон ажил олгогч зэрэг сонирхогч талууд цаг үеийн мэдээллийг нэг эх үүсвэрээс авч байгаад сайшаалтай байна.

*Зөвлөмж:*

- Гадаадад сурталчлах, салбарт түгээх асуудалд анхааран ажиллах

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

## 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн Захирлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/213 дугаар тушаал, түүний хавсралтын гуравдугаар бүлэг болон 2019.05.30-ны өдрийн А/213 дугаар тушаалын хавсралт “Соёл Урлагийн Их Сургуулийн бакалаврын сургалтын журам”.
- СУИС нь 2014 оноос UNICULTURE системийг удирдлагын үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр элсэгчдийн бүртгэлийг онлайн ариунаар хийх болсон. Ингэснээр бүртгэлийн үйл ажиллагааны аливаа хүндрэлийг арилгаж Монгол улсын хаана ч байсан интернетээр бүртгүүлэх боломж бүрдсэн талаар тайланд тодорхой дурдсан байна.
- СУИС-ийн захирлын 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/234 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт8 -ын дагуу “Шилдэг судлаач оюутан”-д тэтгэлэг олгодог.
- СУИС-ийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/234 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт “СУИС-ийн оюутнаар хөдөлмөр эрхлүүлэх, Магистрант, Докторантыг туслахаар ажиллуулах журам”.
- СУИС-ийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/234 дугаар тушаал “СУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох журам”, СУИС-ийн захирлын 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дугаар тушаал.
- СУИС-ийн бакалаврын өдрийн ангид оюутан элсүүлэх журмын дагуу элсэгчдэд дараах хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:
  - ЭЕШ-ын оноогоор тэнцэж элссэн суралцагч нь ЕБС-д сурч байхдаа оюун ухаан, авъяасаа хөгжүүлж, бүс, аймгийн хэмжээний олимпиадын эхний таван шагналт байрын батламж, диплом, медаль авч байсан бол эхний жилийн сургалтын төлбөрийн 30 хүртэлх хувийг.
  - Олон улс, улсын хэмжээний уралдаан, наадам, олимпиадад оролцож байсан бол эхний жилийн сургалтын хөтөлбөрийн 50 хүртэлх хувийг.
  - Олон Улсын болон улсын хэмжээний уралдаан, наадам, олимпиадад оролцож медальт байрны батламж, диплом медаль авч байсан бол эхний жилийн сургалтын хөтөлбөрийн 100 хүртэлх хувийг хөнгөлнө.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Элсэгчийн уралдаан тэмцээнд оролцсон байдлаас үүдэн хөнгөлөлт үзүүлдэг.
- СУИС-аас Бүтээлч оюутан төслийн уралдаан зарлаж шалгарсан төсөл хөтөлбөрүүдийг 5 хүртэлх сая төгрөгөөр санхүүжүүлдэг.
- Удирдлагын мэдээллийн UNICULTURE системийн оюутны программ (<http://student.mnu.ac.edu.mn>)-ыг ашиглан хичээл сонголтыг хэрхэн хийх тухай мэдээлэл.

- “Оюутны хөгжил төв”-ийн дэргэд “Мэдээллийн төв”-ийг ажиллуулж, СУИС-д ирсэн зочид, сонирхсон хэн бүхэнд шаардлагатай мэдээллийг хүргэх үйлчилгээ үзүүлж, мэдээллийн төвд ажиллах хүсэлтэй II-III курсийн оюутнуудыг сонгон шалгаруулалт хийж тэдэнд зохих журмын дагуу, сар бүр хөдөлмөрийн хөлс олгож ажиллуулдаг. Сүүлийн таван жилийн хугацаанд нийт 221 оюутан хөдөлмөр эрхэлсэн байна.
- Суралцагч оюутнуудын дунд Утаснаасаа уралдъя I, II уралдаан, Бүтээлч оюутан төслийн уралдааныг зарлаж ирүүлсэн е-контентуудыг нийгэмд нээлттэй сурталчилж байна.
- Хөтөлбөрийн оюутнууд өөрсдөө мэргэжлээ сурталчлах үүднээс 2 төслийг санаачлан санхүүжилт авч амжилттай хэрэгжүүлж дуусгажээ.

*Анхаарах асуудал:*

- Аялал жуулчлалын мэргэжлээр оюутан татах үйл ажиллагааг сайжруулах;
- Мэргэжлээ таниулах үйл ажиллагаа дутмаг байгаад анхаарах;
- Ажил олгогч, мэргэжлийн зөвлөлтэй хамтран ажиллах;

*Зөвлөмж:*

- Төгсөгчид, ажил олгогчидтойгоо хамтарч ажиллах, оюутнаа ажлын байранд цалинтай дадлагажуулах;
- Хичээлийн жилийн турш элсэгч татах үйл ажиллагаа зохион байгуулах;

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

*Илрэл нотолгоо:*

- Оюутан суралцагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн цагдаагийн хэлтэстэй хамтран сургалт явуулдаг. Жил болгоны 09 сарын эхний 7 хоногт Чингэлтэй дүүргийн цагдаагийн газраас мэргэжилтэн урьж “Гэмт хэрэг эрсдэл”-ийн сургалт зохион байгуулдаг.
- Багш нар оюутнуудаа хөтөлбөрт элсэхэд нь дэмжин тусалдаг талаар тайланд дурдсан байна.
- Түүнчлэн СУИС-ийн нийт оюутнуудад хөтөлбөрөөс үл хамааран заавал үзэх S. BP101 кодтой “Хүний хөгжил” 3 кр цагийн хичээл байдаг ба S.MT101 кодтой “Иргэний хамгаалалт, гамшгийн менежмент” 1 кр, S.ET101 кодтой “Ёс зүй” 2 кр хичээлүүд сонголтоор байдаг. Эдгээр хичээл нь хувь хүний төлөвшилд олон талын ач холбогдолтой юм.
- “Оюутны хөгжил хөтөлбөр”-тэй уялдуулан Оюутны зөвлөл, Сургалтын алба, тэнхимээс жил бүр тодорхой төлөвлөгөөг боловсруулан ажил үйлчилгээ явуулдаг. Үүнд:
  - СУИС-ийн оюутан бүрд сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээлийн үйлчилгээ, дэмжлэгийг бодитой, хүртээмжтэй болгох чиглэлээр.

- Оюутны бие даасан бүтээлч үйл ажиллагааг дэмжих замаар тэдний хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр.
- Оюутанд үзүүлж буй зөвлөх үйлчилгээний чанарыг Оюутны Үйлчилгээ, Хөгжлийн Газар төвлөрүүлэн үнэлдэг бөгөөд зөвлөх багшийг ажиллуулах журамтай. Журамд зөвлөх багшийн эрх, үүргийн тухай дэлгэрэнгүй тусгасан ба оюутанд хүргэх зөвлөн туслах үйлчилгээг чанаржуулж, урамшуулах зорилгоор сайн ажилласан багш нарыг хичээлийн жилд нэг удаа “Оны шилдэг оюутны зөвлөх багш” хэмээн шалгаруулдаг.

### *Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

#### *Онцлог зүйл/Туршлага:*

- Оюутныг амжилттай суралцах, эзэмшихээр суралцаж буй мэргэжилд нь чиглүүлэх, оюутны өөрийн удирдлагын байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилготой нийт суралцагчдад хэрэгцээтэй мэдээ, мэдээлэл түгээх, шинээр элссэн оюутнуудыг чиглүүлэх, зөвлөх, шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамруулах, дэмжиж урамшуулах, тэтгэлэгт болон оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, хөгжил төлөвшил болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төгсөгчдийг ажлын байранд зуучлах зэрэг гол үйл ажиллагааг нэгжүүдийн бүтэц зохион байгуулалттай хэрэгжүүлдэг байна. (ӨҮТ 88-р тал зураг 5.1. Оюутанд үзүүлэх үйлчилгээ)

#### *Анхаарах асуудал:*

- Оюутныг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжин туслах үйл ажиллагаа дутмаг байна.
- Ажил хийж байгаа оюутны судалгаа байхгүй.

#### *Зөвлөмж:*

- Оюутнаа дадлагажуулахад онцгойлон анхаарахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлд зуучлах;
- Ажлын байранд бэлтгэх, мэргэжилд нь ойртуулахад анхаарах;

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### *Илрэл нотолгоо:*

- 2018 оны төгсөгчид сайн дурын үндсэн дээр сайн үйлсийн аян, үндэсний өв соёлын өдөрлөгийг зохион байгуулсан. /ЕБС 5-р сургуулийн 2 бүлэг/
- 2017 18 19 Соёлын наадмыг өртөөчлөн зохион байгуулалтад тогтмол оролцдог.
- 2019 2020 Чингэлтэй фестиваль жил болгон мэргэжлээ сурталчилдаг.
- 2019-2020 онд “Хөтчийн зөвлөх” төсөл хэрэгжүүлсэн өөрсдөдөө зориулсан гарын авлага 2021.
- 2019-2020 онд “Оюутны хөгжлийн өргөө” төсөл, сургалтын хэрэглэгдэхүүнийг уламжлалт тоглоомын аргаар баяжуулах зорилготой. 4 хайрцаг хорло тоглоом, 8 төмөр оньсон тоглоомыг хичээлийн хэрэглэгдэхүүн болгосон байна.
- Аялал жуулчлалын номын санг үүсгэн байгуулахад ном хандивласан байна.

- Аялал жуулчлалын салбарын оюутны чуулганы зохион байгуулах ажлын хэсэгт жил бүр уламжлал болон оролцож, хэвшсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- СУИС-ийн захирлын 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/234 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу “Шилдэг судлаач оюутан”-д тэтгэлэг олгодог. СУИС-ийн хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар тэргүүлсэн оюутанд тэтгэлгийг хичээлийн жилд нэг удаа олгодог. Мөн журамд заасанчлан “Шилдэг судлаач оюутан”-д олгох тэтгэлэг нь нэг хичээлийн жилд 6 хүртэл оюутанд олгогддог ба тэтгэлгийн хэмжээ 500,0 төгрөг хүртэл байдаг.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн оюутнууд “Соёлын аялал жуулчлал” нэртэй клубтэй ба жил бүр зөвлөх багштайгаа хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилладаг байна.

*Анхаарах асуудал:*

- СУИС-ийн хэмжээнд зохион байгуулж буй ажилд хөтөлбөрийн оюутны оролцоог нэмэгдүүлэх.
- Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн туслах зарим үйлчилгээг тодорхой хэмжээгээр үзүүлж байгаа хэдий ч тэдний сэтгэл ханамж ямар түвшинд байгаа болохыг байнга дүгнэж, тодорхой арга хэмжээ авч ажиллах.

*Зөвлөмж:*

- Сайн дурын ажлын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах, ижил мэргэжлийн болон бусад мэргэжлийн оюутнуудтай хамтарч ажиллах;
- Оюутны чөлөөт цагийн клубийн үйл ажиллагааг дэмжиж, тогтмолжуулах;
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүгнэж, үнэлж хэвших;

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн Захирлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны А/213 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын сургалтын журам”.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ СУИС-ийн Бакалаврын сургалтын журмаар зохицуулдаг. Мөн оюутанд чөлөө олгох, гадаад, дотоодын их, дээд сургуулиудаас оюутан шилжин ирж суралцах, мөн СУИС-ийн бүрэлдэхүүн сургууль хооронд шилжүүлэн суралцуулах, СУИС-ийн оюутныг сургуулиас чөлөөлөх зэрэг үйл ажиллагааг “СУИС-ийн оюутны шилжилт хөдөлгөөний журам”-ыг баримталдаг. Энэхүү журмыг оюутны эрх ашигт нийцүүлэн 2012, 2015, 2018 онуудад шинэчлэн боловсруулж



мөрдөж иржээ. Шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ холбогдох баримтуудад үндэслэдэг байна. (ӨYT 95-р тал, Хүснэгт 5.8. Сүүлийн 5 жилээр Соёлын сургуулийн Соёлын сургуулийн Аялал жуулчлал хөтөлбөрөөр суралцагсдын шилжилт хөдөлгөөн)

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Соёлын Сургуулийн ахиц дэвшлийн тайлан судалгааг жил бүр хийж шилжилт хөдөлгөөний байдалд Сургалтын Алба дүн шинжилгээ хийдэг. Үүнийгээ захиргаа, багш нарт танилцуулдаг.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн оюутнуудын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байгаа ба өөр сургууль, мэргэжлийн ангиас шилжиж ирэх оюутны тоо нэмэгдсэн байдал харагдаж байна.

*Анхаарах асуудал:*

- Сонирхон суралцах оюутны тоо цөөрсөн.
- Сүүлийн хоёр жил хүүхдийн тоо, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан дадлагуудыг хойшлуулж байгаад дүгнэлт хийж, аливаа бэрхшээлтэй нөхцөлд хэрхэн гүйцэтгэх шийдэл, гарц олох.
- Гадаадын ижил мэргэжлээр сургалт явуулдаг сургуулиудтай хамтарсан хөтөлбөр байхгүй.

*Зөвлөмж:*

- Уг хөтөлбөрийн хувьд зах зээлийн нийгэмд эрэлттэй байгаа тул оюутан татах, шилжих, гадаад оюутан элсүүлэх, ижил мэргэжлийн хөтөлбөр, сургуультай харилцан солилцоогоор хамтарч ажиллахаас гадна хос болон хавсарга хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Гадаадын аль нэг сургуультай хамтрах, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

## **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

*Илрэл нотолгоо:*

- Монгол Улсын Боловсролын Тухай Хууль, Дээд Боловсролын Тухай Хууль, Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2006 оны 480 дугаар тушаал, Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2012 оны 01 тоот тушаал, Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яамны сайдын “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” А/78 тоот тушаал, СУИС-ийн захирлын 2019 оны 5-р сарын 30-ны өдрийн А/213 тушаалын хавсралт “Соёл Урлагийн Их Сургуулийн бакалаврын сургалтын журам”-ыг үндэслэн СУИС-ийн дүрэм, дотоод журамд нийцүүлэн диплом олгох журмыг баталсан.

- Төгсөлтийн шалгалтын тушаалууд 2019.05.30-ны өдрийн А/213 тоот тушаал, түүний хавсралт болох “Соёл урлагийн их сургуулийн бакалаврын сургалтын журам”-аар төсөл, судалгаа, төгсөлтийн ажил хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулагддаг байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Төгсөлтийн баримт бичгийн хуулбарыг сургуулийн архив, бичиг хэрэгт хадгална. Бакалаврын диплом дээр СУИС-ийн захирал, салбар сургуулийн захирал, сургалтын албаны дарга, төгсөлтийн шалгалтын комиссын дарга нар тус тус гарын үсэг зурж, тамга даран албажуулдаг. Дипломын дүнгийн хуулбар СУИС-ийн сургалтын албаны мэдээллийн санд хадгалагдаж, тухайн төгсөгч гадаад, дотоодын их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, төгсөгчийн талаарх албаны лавлагааг архиваас гаргаж өгөх боломжтой.

*Анхаарах асуудал:*

- Төгсөлтийн шалгалт, дипломын ажил тушаалаар хэрэгжүүлэхээс гадна төгсөлтийн ажил болон төгсөлтийн шалгалтын удирдамжийг боловсруулан, оюутанд хүргэх.
- 2020 оны сургалтын төлөвлөгөөний шинэчлэлээр 3 мэргэжлээр салж байгаа тул дипломын загварууд гаргах.

*Зөвлөмж:*

- Оюутнууд үйлдвэрлэлийн дадлага хийх явцдаа гэрээт байгууллагуудыг түшиглэн төгсөлтийн ажлаа хийх, дипломын ажлаа бичих боломжийг хангах;
- Төгсөлтийн үйл ажиллагааны тайлангууд гаргах, он дарааллаар баримтжуулах;

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн мастер төлөвлөгөө.
- СУИС-ийн Удирдах Зөвлөлийн 2019 оны 4-р сарын 3-ны өдрийн 01 тоот тогтоолын хавсралт “СУИС-ийн дүрэм”.

- СУИС-ийн захирлын 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн А/160 дугаар тушаалын хавсралтаар “Соёл урлагийн их сургуулийн хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан.
- СУИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм.
- СУИС-ийн захирлын 2015 оны 9-р сарын 15-ны өдрийн А/227 тоот тушаалаар батлагдсан “Профессор, багш, ажилтан, ажилчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”.
- СУИС-ийн захирлын 2018 оны 4-р сарын 5-ны өдрийн А/93 тоот тушаалаар батлагдсан Ажлын байрны (албан тушаалын) тодорхойлолтууд.
- СУИС-ийн захирлын 2018 оны 6-р сарын 25-ны өдрийн А/230 тоот тушаалын 2-р хавсралт “СУИС-ийн тэнхимд тавигдах шаардлага, профессор, багш ажиллуулах журмын” 11 дэх хэсэг буюу “Багш нарын хичээлийн жилд гүйцэтгэх цагийн хэмжээ”-д зааснаар багшийн цагийн ачааллыг тооцож байна.
- Доктор зэрэгтэй баг нарын эзлэх хувь Аялал жуулчлалын хөтөлбөрийн хувьд 33% буюу нийт 24 багшийн 8 (ӨҮТ, хүснэгт 6.6) байна.
- Цагийн ачаалал-проф.8, ах.багш 18, багш-дадлагжигч 19 кредит байна. Үндсэн мэргэжлийн 2 багшийн хувьд цагийн гүйцэтгэл 20-24 гардаг. (ӨҮТ, 107-р тал, хүснэгт 6.10)

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Сүүлийн 8 жилд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нараас 4 багш докторын зэрэг хамгаалж, 2 багш докторантурын сургалтыг дүүргэсэн.
- Хөтөлбөрийн багш нараас 2018 онд 2, 2019 онд 2 багш тус тус докторын зэрэг хамгаалсан.

*Анхаарах асуудал:*

- Сүүлийн жилүүдэд хөтөлбөрт ахмад тэргүүлэх багш нарыг ажлаас чөлөөлсөн боловч гаднаас багшийн сонгон шалгаруулалт явагдаагүй.
- Соёл болон Аялал жуулчлалын салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, хичээл заалгах, диплом удирдуулах зэргээр ажиллуулах талаар дутагдалтай.

*Зөвлөмж:*

- Гаднаас өндөр мэргэжлийн багш, судлаач, салбарын мэргэжилтнүүдийг зочин профессор, цагийн багш зэрэг албан тушаалд урилгаар ажиллуулах нөхцөл бололцоог нэмэгдүүлж, татан оролцуулах шаардлагатай.

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн захирлын 2012 оны 6-р сарын 11-ний өдрийн А/137 тоот тушаалаар батлагдсан “СУИС-ийн Хүндэт доктор, Хүндэт профессор” цол олгох журам.
- СУИС-ийн захирлын 2012 оны 6-р сарын 11-ний өдрийн А/137 тоот тушаалаар батлагдсан “СУИС-ийн дэд профессор, профессор цол олгох журам”.
- СУИС-ийн захирлын 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг батлах тухай А/444 тоот тушаалын хавсралтаар “СУИС-ийн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөөт ажлууд хэрэгжиж хөтөлбөрийн багш нар жигд хамрагдан ажиллаж байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- СУИС-ийг хөгжүүлэх матсер төлөвлөгөөний дагуу багшийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч соёл судлалын тэнхимийн нийт багш нар зөвхөн 2020-2021 оны хичээлийн жилд 5 удаа сургалтад хамрагджээ.
- 2022 оны 5 сард Европын Холбооны ERASMUS хөтөлбөрийн “Ажил дээрх дадлагад суурилсан сургалтыг нэвтрүүлэх замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” MONGWBL /2021-2023/ төслийн хүрээнд аялал жуулчлалын мэргэжлийн багш нар Франц улсад мэргэжил дээшлүүлсэн.
- Соёл судлалын тэнхимийн багш нар мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хангалттай сайн хамрагдсан байна. Зөвхөн 2020-2021 оны хичээлийн жилд нийт багш нар 5 удаа сургалтад хамрагджээ.
- Мөн СУИС-ийн зардлаар нийт багш нарыг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг.

*Анхаарах асуудал:*

- Багшийн хөгжлийн хөтөлбөр үндсэн мэргэжлийн багш нарын хувьд хэр биелэлттэй байгаа нь тодорхойгүй.
- Хамрагдсан сургалтууд нь боловсролын буюу сургуулиас зохион байгуулсан нийтлэг сургалтууд байна.
- Залуу багш нарын мэргэжил дээшлүүлэлт хязгаарлагдмал, зөхөн ахмад багшийг дагалдан суралцах хэлбэр илүү зонхилж байна.
- Залуу багш, судлаач нарын хувьд чухал шаардлагатай үйлдвэрлэлд мэргэжил дээшлүүлэх талаар тодорхой зорилго, төлөвлөгөө байхгүй.

*Зөвлөмж:*

- Мэргэжлийн үндсэн багш нарыг аялал жуулчлалын үйлдвэрлэлийн салбарт мэргэжил дээшлүүлэх, тогтмол дадлагажих бодлого боловсруулж, арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

### 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### *Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд чиглэсэн нийтдээ 10 гаруй бодлогын баримт бичгүүд, дүрэм журмууд хүчинтэй үйлчилж байна.
- Соёлын сургууль нь “Монгол соёл иргэншлийн үүсэл, түүхэн хөгжлийн мөн чанар, аюулгүй оршихуйн язгуур дархлаа ба даяаршлын үр дагаврын судалгаа” хэмээх тэргүүлэхчиглэлийг тогтоосон. Энэхүү тэргүүлэх чиглэл нь дараах 3 үндсэн чиглэл хуваагдана. Үүнд:
  - “Монгол хүн, нүүдлийн уламжлалт соёл иргэншил, байгалийн язгуур шүтэлцээ, өвлөгдөл, гээгдлийн судалгаа”.
  - “Монгол нүүдлийн соёл иргэншил дэх соёлын үйлдвэрлэлийн уламжлалт менежментийн өв, өвлөгдөл, хувьслын мөн чанарын судалгаа”.
  - “Монгол уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн аюулгүй оршихуйн түүх, философи сэтгэлгээний судалгаа”.
- Соёлын сургууль дотооддоо жил бүр “Багш нарын эрдэм шинжилгээний хурал” зохион байгуулж, шилдэг илтгэлүүд шалгаруулдаг. Тус хуралд Соёл судлалын тэнхимийн багш нар тогтмол амжилттай оролцдог буюу 2017 онд Ж.Мяндас 1-р байр, Б.Мөнхбадрал 2-р байр, 2019 онд Э.Энхсайхан 1-р байр, М.Ганжаргал 2-р байр, 2020 онд Б.Мөнхбадрал 3-р байр, 2021 онд Б.Мөнхбадрал 1р байр тус тус эзэлж байв. Шалгарсан илтгэл, илтгэгчийг “СУИС-ийн Эрдмийн чуулган”-нд илтгэл хэлэлцүүлэх эрх, өгүүллээ “Монголын соёл, урлаг судлал” эрдэм шинжилгээний бичгийн үндсэн болон тусгай дугаарт хэвлүүлэх эрхийн бичиг тус тус олгодог уламжлалтай. Эрдмийн чуулган 2019 онд Э.Энхсайхан 3-р байр, Эрдмийн чуулган 2021 онд Б.Мөнхсайхан 1-р байр эзэлсэн.
- Соёлын сургуулийн эрдэм шинжилгээний хурлын зардал сүүлийн жилүүдэд буурсан боловч эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа шинжилгээний зардал өссөн үзүүлэлттэй байна.

*Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан*

#### *Онцлог зүйл/Туршлага:*

- 2016 оноос хойш Соёлын сургуулийн багш нар жилд дунджаар 14 ном, гарын авлага болон 20 гаруй өгүүлэл хэвлүүлж, 25 орчим илтгэлүүд тавьж хэлэлцүүлж ирсэн.
- Аялал жуулчлалын хөтөлбөрийн үндсэн багш нар энэ хугацаанд жил бүр сургуулийн ба салбарын хэмжээнд 10-25 илтгэл тавьж тухай бүр шалгаран, 3-15 өгүүлүүд хэвлүүлж, 10 гаруй төсөл хөтөлбөрүүдэд хамрагдан ажиллажээ.

#### *Анхаарах асуудал:*

- 2012 оноос хойш батлагдсан ашигтай загвар, патент гараагүй байна.

- Соёлын сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний төсөв, гүйцэтгэл байгаа боловч аялал жуулчлалын хөтөлбөрийн үндсэн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсөв, тайланг гаргаагүй.

*Зөвлөмж:*

- Гадаад, дотоодын сургалт, эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн сэтгүүлд ЭШӨ хэвлүүлэх ажлыг дэмжих, хэвлэгдэх ЭШӨ-ийн тоог нэмэгдүүлэх бодлого баримтлах;

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 5-ний өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан “СУИС-ийн профессор, багш, ажилтныг шагнаж урамшуулах журам”.
- Мөн “СУИС-ийн профессор, багш, ажилчдын ажлын үр дүнг үнэлж, нэмэгдэл хөлс олгох журам”-ыг 2015 оны 3-р сарын 1-нээс батлан мөрдөж байна.
- СУИС-ийн захирлын 2015 оны 5-р сарын 5-ны өдрийн А/147 тоот тушаалын 8-р хавсралт “СУИС-ийн шагнал олгох журам”.
- СУИС-ийн захирлын 2018 оны 6-р сарын 25-ны өдрийн А/230 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Соёл урлагийн их сургуулийн багшийг аттестатчилах журам”-ыг баталсан. Журмын дагуу 2 жил тутамд хөтөлбөрийн багш нар аттестатчилалд орж хэвшсэн.
- Багшийн өөрийн үнэлгээний ба аттестатчлалын журмыг СУИС-ийн хэмжээнд нийтээр мөрддөг. Өөрийн үнэлгээг А,В, С цагийн гүйцэтгэлээр багш нар гаргаж тэнхимийн эрлэгч дүнэдэг ба багшийн аттестатчлалыг 2 жилд нэг удаа хийдэг байна.

*Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*Онцлог зүйл/Туршлага:*

- Сургалтын үйл ажиллагааны үр дүнг “Багш, тэнхимийн эрхлэгч, бүтцийн сургуулийн сургалтын алба, бүтцийн сургуулийн захирал, сургалтын бодлого зохицуулалтын газар”,
- эрдэм шинжилгээний ажлын үр дүнг “Багш, эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрдэм шинжилгээ, инновацийн газар” хэлэлцдэг.
- Уран бүтээлийн ажлын үр дүнг “Уран сайхны удирдагч” гэсэн сургуулийн удирдлагын босоо тогтолцооны түвшин бүрээр үнэлж хяналт тавьж байна.
- Жил бүр оны шилдэг багш, тэнхимийг шалгаруулдаг бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд Соёлын сургуулийн шилдэг тэнхимээр хөтөлбөр хэрэгжүүлэгч Соёл судлалын тэнхим шалгарсан байна.

- Аялал жуулчлал хөтөлбөрийн үндсэн 3 багш нар (Ч.Мөнхжаргал, М.Ганжаргал, Б.Мөнхбадрал) 2020 оны аттестатчлалын дүнгээр А буюу хангалттай сайн үнэлэгдсэн байна.

*Анхаарах асуудал:*

- Аттестатчлалын журам ёсоор нийт үнэлгээний 70% өөрийн, 10% оюутны, 10 удирдлагын үнэлгээнүүд эзэлж байгаа ба цаашид хөндлөнгийн үнэлгээний ач холбогдлыг илүү тооцох шаардлагатай.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар тодорхойгүй, мэдээлэл алга.

*Зөвлөмж:*

- Хөтөлбөрийн үндсэн багш нарын үнэлгээний дүнг сурталчлан алдаршуулах, тэднийг урамшуулан дэмжих олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

*Илрэл нотолгоо:*

- СУИС-ийн дотоод хяналт, шалгалтын журмыг Захирлын 2012 оны 2-р сарын 29-ний өдрийн А-75 тушаалд баталснаар мөрдөн ажиллаж байна. Мөн СУИС-ийн Захирлын 2021 оны А-311 тоот тушаалаар “Эрдэм шинжилгээ, сургалтын чанарын асуудал хариуцсан мэргэжилтний” ажлын байрыг бий болгож баталсан байна.
- СУИС-ийн хэмжээнд дотоод үйл ажиллагааны чанарын удирдлагын тогтолцооны ерөнхий зураглалыг гаргасан (ӨҮТ, 122-р тал, хүснэгт 7.2 ба 7.3).
- СУИС-ийн захирлын 2022 оны 1-р сарын 21-ний өдрийн А/25 тоот тушаалаар батлагдсан “Соёл Урлагийн Их Сургуулийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод чанарын баталгаажуулалтын 2022 оны ажлын төлөвлөгөө.
- “СУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмыг” Захирлын 2014 оны 5-р сарын 22-ны өдрийн А/10 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан. СУИС-ийн хэмжээнд хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажилтын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь Хөтөлбөрийн хорооны журманд заасны дагуу хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороогоор дамжин явагддаг.

*Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- UNICULTURE системийг ашиглан чанарын баталгаажуулалт хийх ажил эхэлсэн явагдаж байна.
- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээг амжилттай хийж, тайланг зохих шаардлагын дагуу бичиж, шалгуур бүрээр PDCA шинжилгээг хийсэн.

*Анхаарах асуудал:*

- Чанарын дотоод баталгаажуулалтын хэрэгжилт, үнэлгээний талаар баримт, нотолгоо хангалтгүй.

*Зөвлөмж:*

- Тэнхим, сургуулийн хэмжээнд Чанарын Менежментийн Тогтолцооны ISO 9001:2016 болон Боловсролын Менежментийн Тогтолцооны ISO 21001:2018 стандартын сургалт зохион байгуулах, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах.

*Шаардлага:*

- Соёлын сургууль ба Аялал Жуулчлал хөтөлбөрийн хувьд чанарын баталгаажилтад оролцогч талуудын оролцоог хангах. Үүнд хөтөлбөрийн дэд хороонд гаднын ажил олгогч талын төлөөллийг оруулах.

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

*Илрэл нотолгоо:*

- Суралцаж байгаа оюутнуудаас намар, хаврын улирлын шалгалтын үеэр UNICULTURE систем дээр сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг.
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2021 оны 4-р сарын байдлаар Соёлын сургуулийн 5 хөтөлбөрийн төгсөгчдөөс авч, зохих дүн шинжилгээг хийсэн байна. Энэхүү судалгаанд “Аялал жуулчлал” хөтөлбөрийн 27 төгсөгч хамрагдсан нь энэ хөтөлбөрөөр тайлант хугацаанд төгсөгчдийн 43%-ийг эзэлж байна.

*Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Нийт төгсөгчдийн тал хувь нь 1-2 жилийн хугацаанд ажилд орсон байна.
- Сургуулиас олж авсан мэдлэг, чадвараа төгсөгчдийн 40 илүү хувь нь боломжийн, карьер төлөвлөлт амжилттай гэж үнэлсэн нь төгсөгчдийн ур чадвар зохих түвшинд байгааг харуулж байна.

*Анхаарах асуудал:*

- Хөтөлбөрийн ерөнхий ба дэд хорооны бүрэлдэхүүн, чадамж нь чанарын дотоод баталгаажилтыг хангахад чиглэгдсэн боловч нарийн мэргэжлийн болон ажил олгогчийн төлөөлөл байхгүй.



- Хөндлөнгийн баталгаажуулалтыг цаашид бий болгож, сайжруулах бодлого төлөвлөлт тусгагдаагүй.

*Шаардлага:*

- Төгсөгчдийн холбоо, клуб байгуулах хэлбэрээр төгсөгчидтэй байнгын холбоо тогтоож, тэдний санал үнэлгээг хөтөлбөрт тусгаж ажилах.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

*Илрэл нотолгоо:*

- “Аялал жуулчлал” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд холбогдох мэргэжлийн Холбоод болон хөндлөнгийн байгууллагуудаар үнэлгээ хийлгэж байгаагүй.

*Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан*

*Онцлог зүйл/Туршлага:*

- Европын Холбооны ERASMUS хөтөлбөрийн “Ажил дээрх дадлагад суурилсан сургалтыг нэвтрүүлэх замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” MONGWBL /2021-2023/ төслийн хүрээнд хөтөлбөрийн шинэчлэл хийж, дадлагад суурилсан сургалтыг хэрэгжүүлэх чиглэлээр нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, цаашдын сайжруулалтыг явуулахаар ажиллаж байна.

*Анхаарах асуудал:*

- Хөндлөнгийн баталгаажуулалтыг цаашид бий болгож, сайжруулах бодлого төлөвлөлт тусгагдаагүй.

*Зөвлөмж:*

- Тэнхим, сургуулийн хэмжээнд Чанарын Менежментийн Тогтолцооны ISO 9001:2016 болон Боловсролын Менежментийн Тогтолцоо ISO 21001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэх.

*Шаардлага:*

- Хөндлөнгийн баталгаажуулалтын талаар бодлого төлөвлөлттэй болох, хэрэгжүүлэх

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

ДҮГНЭЛТ

СУИС-ийн Соёлын Сургуулийн “Аялал жуулчлал” хөтөлбөрийн үнэлгээ

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан	
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан-1.1, 1.2, 1.3	-	-	Хөтөлбөрийн төлөвлөлт шаардлага хангаж байгаа.
2	Сургалтын үйл ажиллагаа	Бүрэн хангасан 2.2, 2.3	2.1	-	Хөтөлбөрийн PLO, CLO-гийн уялдаа холбоо болон суралцахуйн үр дүнг бодитой тооцох,
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Бүрэн хангасан 3.1, 3.2	3.3	-	Хөтөлбөрийн мэргэжлийн ном, сурах бичгийн хангалтыг сайжруулах шаардлагатай.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Бүрэн хангасан 4.1 4.2, 4.3, 4.5	4.4	-	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг төгөлдөршүүлэх шаардлагатай. Сурталчилгаа, маркетингийн идэвхижүүлэлтийг зорилтот бүлэгт чиглүүлэн өргөжүүлэх ажлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Бүрэн хангасан 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5		-	Төгсөлтийн үйл ажиллагааны тайлангууд гаргах, он дарааллаар баримтжуулах шаардлагатай.
6	Багшийн үйл ажиллагаа	Бүрэн хангасан-6.1, 6.2, 6.3, 6.4	-	-	Багшийн үйл ажиллагаа нь магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангаж байгаа.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	-	7.1, 7.2, 7.3		Хөндлөнгийн баталгаажуулалтыг цаашид бий болгож, сайжруулах бодлого арга хэмжээний төлөвлөлтгүй.
	<b>НИЙТ-26 дэд шалгуурууд</b>	<b>20</b>	<b>6</b>		
	Дүгнэлт	Нийт 7 үндсэн шалгуурын 6 шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН ба “Чанарын үнэлгээ, баталгаажилт” шалгуурын шаардлагыг “ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН” гэж Шинжээчийн баг дүгнэв. Ерөнхий дүгнэлт-Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг <b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургуулийн “Аялал жуулчлал” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ ....**БҮРЭН ХАНГАСАН**....” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Аялал Жуулчлал ..чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Д.ГАНСҮХ

Шинжээчийн багийн гишүүн: С.НОРЖИНЛХАМ

Шинжээчийн багийн гишүүн: Н.БАТЦЭНГЭЛ

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	СУИС-ийн Соёлын Сургууль
Хөтөлбөрийн нэр	Аялал жуулчлал
Хөтөлбөрийн индекс	D101501
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	Хөтөлбөрийг Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2022 оны 5-р сарын 09-ний өдрийн А/160 тушаалаар батлагдсан хөтөлбөрийн индексийн дагуу сайжруулан шинэчлэх.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	Багш нарын сургалтын арга зүйд дүн шинжилгээ хийх, сургуулийн удирдлага ба хөтөлбөрийн зүгээс туслан дэмжиж, хөгжүүлэх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	Оюутны мэргэжлийн дадал, чадварыг хөгжүүлэх сургалтын лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлж, ашиглах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Хөтөлбөрийн дэд хорооны бүтцэнд аялал жуулчлалын салбарын төлөөллийг гаднаас оруулах
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	Мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	Мэргэжлийн багш нарыг үйлдвэрлэлд мэргэжил дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллахад Сургуулийн удирдлагын зүгээс тодорхой дэмжлэг үзүүлэх.
<b>ШААРДЛАГА</b>	
Шаардлага 2.1	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн дэд хороонд сонирхогч талууд, түүний дотор аялал жуулчлалын салбарын төлөөллийг оруулж хөтөлбөрийн сургалтыг агуулгыг сайжруулахад хамтран ажиллах;</li> <li>- Оюутан солилцооны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх /дотоод ба гадаад/;</li> </ul>
Шаардлага 3.3	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын цахим материалуудыг илүү боловсронгуй болгон E-контентын түвшинд хөгжүүлж сайжруулах;</li> <li>- Олон улсын түвшинд нэвтэрч буй судалгааны болон эрдэм шинжилгээний бүтээлүүдээр баяжуулах;</li> <li>- Аялал жуулчлалын хөтөлбөрийн мэргэжлийн сурах бичиг, гадаад хэлээр ашиглах ном сурах бичгийн хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх;</li> </ul>
Шаардлага 4.4	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг гадаад зах зээлд сурталчлан ажиллаж элсэгчид судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх;</li> </ul>
Шалгуур 7	<ul style="list-style-type: none"> <li>- Чанарын баталгаажилтад оролцогч талуудын оролцоог хангах. Үүнд хөтөлбөрийн дэд хороонд гаднын ажил олгогч талын төлөөллийг оруулах;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"><li>- Төгсөгчдийн холбоо, клуб байгуулах хэлбэрээр төгсөгчидтэй байнгын холбоо тогтоож, тэдний санал үнэлгээг хөтөлбөрт тусгаж ажилах;</li><li>- Хөндлөнгийн баталгаажуулалтын талаар бодлого төлөвлөлттэй болох, хэрэгжүүлэх;</li></ul>
--	--

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### а. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ж.Долгорсүрэн	Тэргүүлэх профессор	Ph. D,	30-аас дээш /ССТ-15, Тайлант хугацаанд 2 жил/	
2	Д.Тангад	Гэрээт багш	Ph. D,	30-аас дээш, /ССТ-9, Тайлант хугацаанд 3/	Монголын угсаатны зүй
3	С.Юндэнбат	Гэрээт багш	Ph. D,	30-аас дээш, /ССТ-15, Тайлант	Соёлын биет ба биет бус өв судлал
4	Ч.Мөнхжаргал	Ахлах багш, /ТЭ/	Ph. D,	СДС-11, ССТ-11	Хөтөч тайлбарлагчийн арга технологи, Зочид буудал, зоогийн
5	Б.Мөнхбадрал	Тэнхимийн эрхлэгч	Ph. D	ССТ-13	Аялал жуулчлалын үндэс, Монголын аялал жуулчлал,
6	Ж.Мяндас	Тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан	Ph. D	30 /ССТ-3, Тайлант хугацаанд 2/	Дэлхийн соёлын түүх
7	М.Ганжаргал	Ахлах багш	Магистр	ССТ-17	Соёл судлал, Соёлын онол, Соёл хоорондын харилцааны үндэс
8	Х.Идэрмөрөн	Багш	Магистр	ССТ-17	Монгол бичиг
9	Э.Энхсайхан	Багш	Магистр	ССТ-9	Монголын соёлын түүх,

##### б. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	М. Төгсбаясгалан	I	Шинэ элсэгч – УБ хотын төлөөлөгч
2	А. Даваа-Эрдэнэ	I	Шинэ элсэгч – Орон нутгийн төлөөлөгч, Дундговь аймаг
3	А. Энхзаяа	II	Оюутны төслийн удирдагч
4	Ц. Энхжин	II	УБ хотын төлөөлөгч, өндөр голчтой оюутны төлөөлөл
5	Б. Анужин	II	УБ хотын төлөөлөгч
6	Л.Нандин-Эрдэнэ	II	УБ хотын төлөөлөгч
7	Г.Сарнай	II	Шилжилт хөдөлгөөний төлөөлөгч (Гадны сургуулиас ирсэн)
8	Б.Төмөрчөдөр	II	Шилжилт хөдөлгөөний төлөөлөгч (СУИС-ийн бүтцийн сургууль доторх)
9	Б.Ганчимэг	III	Өндөр голчтой оюутан, оюутны байранд амьдарч байсан
10	Ж.Эрдэнэсүвд	III	Шилжилт хөдөлгөөний төлөөлөгч (Хөтөлбөр хоорондын)
11	Т.Мөнхчулуун	IV	Орон нутгийн төлөөлөгч, Ховд аймаг
12	Н.Долгормаа	IV	Орон нутгийн төлөөлөгч, Өвөрхангай аймаг, Оюутны төслийн удирдагч
13	Т.Буянзаяа	IV	УБ хотын төлөөлөгч
14	С.Энхсуварга	IV	Шилжилт хөдөлгөөний төлөөлөгч (Гадны сургуулиас ирсэн)

в. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Ц.Ганцацрал	Замын-Үүдийн Skytel салбар	эрхлэгч
2	Э.Ариунболд	Мөст-Алдар ХХК	захирал
3	Б.Түдэвваанчиг /99086004/	Тарган сарлаг ХХК, Завханы Аялал Жуулчлалын Холбоо	Захирал, дэд захирал
4	Б.Ишбалжир	Mongolkhan Expeditions ХХК	захирал
5	Д.Мөнхтоогоо	МҮМузей	Албаны дарга
6	Батжаргал /91919055/	Пример Агро ХХК	захирал
7	Б.Өмирбек	Монгол-Алтай хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	дарга
8	Э.Ганзориг	Баянхонгор Аймгийн Байгаль, Орчин, Аялал Жуулчлалын Газрын Дарга	
9	М.Мөнхбаяр	Өвөрхангай Аймгийн Бүрд Сумын ЗДТГ	Засаг дарга
10	Д.Ариундэлгэр /96909617/	Сүхбаатар Аймгийн Угсаатны Зүйн Музей	захирал
11	Б.Батзориг	HERO entertainment group	Ерөнхий редактор

г. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	М.Намуун /91105800/	2017	Skytel Замын-Үүд салбар	Борлуулалт үйлчилгээний ажилтан
2	А.Уянга /98883327/	2017	Хувийн англи хэлний сургалт /орон нутагт/	Багш
3	Э.Нарандолгор /88062616/	2017	Unitel Замын-Үүд салбар	Борлуулалт үйлчилгээний ажилтан
4	Ц.Ням-Очир /80913433/	2018	Пример Агро ХХК Бугат кемп	менежер
5	М.Адилбек /95158373/	2018	Монгол-Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	Эрдэм шинжилгээний ажилтан
6	А.Саранчимэг /85114349/	2018	МҮМузей	Сан хөмрөгч
7	А.Гансарнай /95113445/	2018	Сүхбаатар Аймгийн Угсаатны Зүйн Музей	тайлбарлагч
8	С.Лувсан /89430517/	2019	Мөст-Алдар ХХК	Хүний нөөцийн менежер
9	Ц.Хулан /95899698/	2019	МИАТ ХХК	Тийз бичигч
10	Ц.Баасанхүүхэн /88134559/	2020	Дүрслэх урлагийн академи	Сургалтын албаны мэргэжилтэн
11	Б.Мөнхбаяр /85569282/	2021	Өвөрхангай аймгийн Бүрд сумын ЗДТГ	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
12	У.Амарзаяа /88510203/	2021	Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын цэцэрлэг	Туслах багш

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



Тус зөвлөлөөс ирүүлсэн Аялал жуулчлал хөтөлбөрийн шинжээчдийн тайлантай бид танилцлаа. Шинжээчдийн өгсөн санал, зөвлөмжийг бид цаашдын үйл ажиллагаандаа тусгаж, ажиллах болно.

Бидэнтэй хамтран ажилласан та бүхэнд баярлалаа.



Ш.ЭРДЭНЭЦЭЦЭГ

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 2022.06.23

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилсэн	5

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) ..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа